ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 19 өдөр Дугаар А/181 Бор-Өндөр сум

Бог малын мялзан өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/315 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны А/471 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болормаа Мал эмнэлгийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга

Р.Цэндсүрэн Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

Гишүүд

Б.Мөнх-Оргил Хүйх 5-р багийн Засаг дарга

Н.Отгонбилэг Өлгий 6-р багийн Засаг дарга

Малын эмч Ц.Бат-Эрдэнэ

Малын эмч Ц.Төртүвшин

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 2024 онд шинээр гарсан хурга, ишгийг уг өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 14 хоногт багтаан шуурхай зохион байгуулахыг ЭнТэЧи ХХК, Ноён Зүлэгт ХХК (Ц.Төртүвшин, Ц.Бат-Эрдэнэ) мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт даалгасугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дуусанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ

D:/bichig hereg/Захирамж.docx

Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны ....09.... дүгээр сарын
....19....-ний өдрийн ....71/81....захирамжийн 1 дүгээр хавсралт

Бор-Өндөр сумын Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт-2024

№	МЭҮН	Малын тоо толгой		Шаардлагатай вакцин /тун/			Шингэлэгч литр	
		хурга	ишиг	нийт	хайрцаг	задгай	Литр	Шил
1	ЭнТэЧи	3500	3500	7000	3	10	7000	35
2	Ноён Зүлэгт	3995	3505	7500	3	15	7500	37
Дүн		**7495**	**7005**	**14500**	**6**	**25**	**14500**	**72**